



ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

"Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт" нийцлийн аудит

УАГ- НАГ/2016/01-НА-ХөААГ

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2016 оны 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн нийцлийн аудитын тайлан



**ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭРТ ХАЛАМЖИЙН САНГИЙН
ЗАРЦУУЛАГДААГҮЙ ҮЛДЭГДЭЛ 1,2 ТЭРБУМ ТӨГРӨГИЙГ
ТӨЛӨВЛӨЖ ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

2016 оны 04 дүгээр сар

ДҮГНЭЛТ

1. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр хуульд заасан нэр төрөл тус бүрээр бүрэн бүрдээгүй, улмаар халамжийн сангийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төлөвлөж зарцуулсан байна.
2. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулж төлөвлөсөн боловч цаашид ашиглахурсгал зардлын тооцоо хийгдээгүй байна.
3. Аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим хөтөлбөр, төсөл, арга хэмжээ иргэдийн саналаар дэмжигдээгүй, чиг үүрэгт нийцээгүй, төсөвт өртгийг урьдчилан тооцсон, зураг, төсөв нь батлагдаагүй байна.
4. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим хөтөлбөр, төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт, гүйцэтгэлийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж санхүүжүүлээгүй байна.
5. Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг ажлын хэсэг хүлээн авч орон нутгийн өмчид бүртгэх ажлыг хуулийн дагуу зохион байгуулсан байна.
6. Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын алба нь ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлтөд хяналт тавьсан боловч гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй байна.
7. ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдэж буй ажлуудын гүйцэтгэл, хөрөнгийн зарцуулалтыг олон нийтэд ил тод мэдээллэсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн ИТХ, дарга Т.Болдбаатарт:

1. Иргэдийн саналаар дэмжигдсэн, тэдний оролцоог хангасан төсөл арга хэмжээний төслийг ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж байх,
2. Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-т зааж, зөвшөөрсөн аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэлэлцүүлж батлаж байх,
3. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 2014-2015 онд хэрэгжсэн "Мөрөн сумыг өндөр хүчин чадалтай камертай болгох" ажлын хүрээнд бий болсон 600,0 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг бүртгэлд тусгуулж, хариуцах эзэнтэй болгох.
4. ОНХС-гийн хөрөнгөөр бий болсон өмчийн урсгал зардлыг шийдвэрлэж байх

Аймгийн Засаг дарга А.Эрдэнэбаатарт:

1. Иргэдийн саналаар дэмжигдсэн, тэдний оролцоог хангасан хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж байх,
2. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж болох чиг үүрэгт заасан хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байх
3. Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй хөтөлбөр, төсөл, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэхгүй, санхүүжүүлэхгүй байх
4. Дотоод аудитын албаар ОНХС-гийн гүйцэтгэл, санхүүжилтийн байдалд хяналт хийлгэх
5. Хяналтын камерийн гүйцэтгэлийн чанар байдалтай холбоотой асуудлыг чанарын баталгаат хугацааны дотор барьцаа хөрөнгөөр шийдвэрлүүлэх
6. ОНХС-гийн хөрөнгөөр бий болсон өмчийн урсгал зардлыг шийдвэрлүүлж байх

Сумын ИТХ-д:

1. Иргэдийн саналаар дэмжигдсэн тэдний оролцоог хангасан хөтөлбөр, төсөл арга хэмжээг баталж, хэрэгжүүлэх
2. Сумын ОНХС-гаар хэрэгжүүлэх чиг үүрэгт заасан хөтөлбөр, төсөл, арга хэмжээг баталж байх
3. ОНХС-гийн төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт, үнэлгээ хийж, нийтэд ил тод мэдээллэж байх

Сумын Засаг дарга нарт:

1. Иргэдийн саналаар дэмжигдсэн, тэдний оролцоог хангаж санал авсан, сумын ОНХС-гийн чиг үүрэгт нийцсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж байх,
2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн байдалд хяналт тавьж гарсан зөрчлийг тухай бүр арилгуулж байх
3. Хууль, журамд нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж байх

